УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН ТУШААЛ

2022 оны 12 сарын 22 өдөр Дугаар А/275 Улаанбаатар хот

Санхүүжилт батлах тухай

Монгол улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3.1, 24.3.4, 24.6, Төсвийн тухай хуулийн 16-р зүйлийн 16.5.2, 16.5.5, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны Нийслэлийн 2022 оны төсөв батлах тухай 11/34 дүгээр тогтоол, Улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны дүрмийн 2-р хэсгийн 2.2, 3 дугаар хэсгийн 3.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэлийн нутаг дэвсгэрт 2022 оны 11 дүгээр сарын 18, 19-ний өдрүүдэд орсон их хэмжээний цасыг хурдан шуурхай арилгах автозамын хальтиргаа гулгаанаас урдчилан сэргийлэх зорилгоор зарим гэрээт байгууллагын ачаалал ихтэй автозамд нэмэлтээр хүн хүч, машин механзм ажиллуулсан хувийн хэвшийн аж ахуйн нэгжүүдийн гүйцэтгэсэн ажлын зардлыг хавсралт ёсоор баталсугай.

2.Цас цэвэрлэгээний ажилд шаардагдах зардлыг Нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээний зардлаас санхүүжүүлэхийг Төсвийн санхүүжилт, тайлагналт, бүртгэл хариуцсан ахлах нягтлан бодогч Ч.Алтанхүүд зөвшөөрсүгэй.

3.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (С.Жамъяндорж)-т даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Д.ГАНБОЛД

C:\Users\User\Desktop\тушаал.docx

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2022 оны 12 дугаар сарын 22-ны
өдрийн А/275 дугаар тушаалын хавсралт

ЦАС ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ АЖИЛД ЗАРЦУУЛАГДАХ
ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ

№	Дүүрэг	Ажиллах өдөр	Зардлын хэмжээ
1	2	3	4
1	Сонгино-хайрхан дүүрэг	2	1,573,142
2	Хан-Уул дүүрэг	2	17,000,000
3	Налайх дүүрэг	2	13,219,866
	Нийт дүн		**31,793,008**